| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 28,660,000.00 | 28,660,000.00 | 28,660,000.00 | 0.00 |
| 210602 | Тавилга | 12,932,000.00 | 12,212,000.00 | 12,212,000.00 | 0.00 |
| 210604 | Урсгал засвар | 42,320,100.00 | 42,148,500.00 | 42,148,500.00 | 0.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **6,873,300.00** | **6,595,600.00** | **6,595,600.00** | **0.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 6,873,300.00 | 6,595,600.00 | 6,595,600.00 | 0.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **5,061,300.00** | **4,484,470.00** | **4,484,470.00** | **0.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 2,571,800.00 | 2,564,900.00 | 2,564,900.00 | 0.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 324,000.00 | 150,000.00 | 150,000.00 | 0.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 590,000.00 | 590,000.00 | 590,000.00 | 0.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 229,000.00 | 113,350.00 | 113,350.00 | 0.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 48,000.00 | 8,000.00 | 8,000.00 | 0.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 1,142,000.00 | 902,000.00 | 902,000.00 | 0.00 |
| 210807 | Газрын төлбөр | 156,500.00 | 156,220.00 | 156,220.00 | 0.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **102,632,400.00** | **86,864,805.00** | **71,959,587.00** | **14,905,218.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 95,562,200.00 | 80,228,605.00 | 80,228,605.00 | 0.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 7,070,200.00 | 6,636,200.00 | 6,636,200.00 | 0.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **31,971,000.00** | **31,129,872.00** | **31,129,872.00** | **0.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **31,971,000.00** | **31,129,872.00** | **31,129,872.00** | **0.00** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 30,569,700.00 | 29,728,572.00 | 29,728,572.00 | 0.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,401,300.00 | 1,401,300.00 | 1,401,300.00 | 0.00 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **142,526,800.00** | **88,276,800.00** | **88,276,800.00** | **0.00** |
| 223001 | Бусад хөрөнгө | 142,526,800.00 | 88,276,800.00 | 88,276,800.00 | 0.00 |
| **23** | **ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ** | **184,930,200.00** | **2,615,000.00** | **2,615,000.00** | **0.00** |
| 230001 | Эргэж төлөгдөх зээл | 184,930,200.00 | 2,615,000.00 | 2,615,000.00 | 0.00 |
| **III** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **2,720,254,900.00** | **2,600,219,369.00** | **2,615,882,182.80** | **-269,810,513.80** |
| **31** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,508,378,600.00** | **1,508,378,700.00** | **2,317,068,107.00** | **-955,746,481.00** |
| 310001 | Улсын төсвөөс санхүүжих | 0.00 | 0.00 | 808,689,407.00 | -701,598,781.00 |
| 310003 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,508,378,600.00 | 1,508,378,700.00 | 1,508,378,700.00 | -254,147,700.00 |
| **32** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **944,875,700.00** | **947,908,507.00** | **129,509,400.00** | **711,308,481.00** |
| 320002 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | 129,509,400.00 | 129,509,400.00 | 129,509,400.00 | 0.00 |
| **33** | **НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **28,343,300.00** | **29,196,420.00** | **29,196,420.00** | **0.00** |
| 330002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | 28,343,300.00 | 29,196,420.00 | 29,196,420.00 | 0.00 |
| **35** | **ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС** | **238,657,300.00** | **114,735,742.00** | **140,108,255.80** | **-25,372,513.80** |
| 350001 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 173,551,700.00 | 105,051,422.00 | 105,051,422.00 | 0.00 |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 350002 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 24,199,900.00 | 9,684,320.00 | 9,684,320.00 | 0.00 |
| 350003 | Урьд оны үлдэгдлээс санхүүжих | 40,905,700.00 | 0.00 | 40,905,794.80 | -40,905,794.80 |

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Код | Үзүүлэлт | ТЗ цэвэр дүн |
|---|---|---|
| **II** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **197,770,853.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **197,770,853.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **170,720,853.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **56,273,100.00** |
| 210101 | Үндсэн цалин | 8,393,100.00 |
| 210104 | Урамшуулал | 47,880,000.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **7,262,751.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 7,262,751.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **4,420,000.00** |
| 210303 | Цэвэр, бохир ус | 4,420,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **10,446,099.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 998,007.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 3,667,400.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 35,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 5,745,692.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **75,497,636.00** |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 70,032,590.00 |
| 210502 | Хоол, хүнс | 5,219,500.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 245,546.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **500,000.00** |
| 210604 | Урсгал засвар | 500,000.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **290,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 290,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **15,231,267.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 15,231,267.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **800,000.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 500,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 300,000.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **27,050,000.00** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **26,600,000.00** |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 26,600,000.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **450,000.00** |
| 213405 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг | 450,000.00 |
| **I** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **197,770,853.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **197,770,853.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 86,349,422.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 111,421,431.00 |

## 3.Аудитын тайлан

### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Баруунбаян-Улаан сумын Төрийн сангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитыг 2022.03.16-нөөс 2022.03.25–ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2022.03.24-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Ц.Мөнхзаяа хариуцаж хэрэгжүүлэв.

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Өвөрхангай аймаг дахь төрийн аудитын газарт 2022.02.22-ны өдрийн 1/41 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

Сумын төрийн сангийн нэгтгэсэн тайланд 6 төсөвт байгууллага, 3 сан, 1 ерөнхий орлогын данс нийт 10 тайлан нэгтгэджээ.

### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Төсвийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1."Төсвийн ерөнхийлөн захирагч нь өөрийн удирдлага дор төсвийн шууд захирагчийг харьяалах эрх бүхий төсвийн төвлөрүүлэн захирагчтай байж болно." гэж заасан.

Мөн хуулийн 36.1."Төрийн сангийн тогтолцоо нь төв төрийн сан, аймаг, нийслэлийн төрийн сан, сум, дүүргийн төрийн сан, төрийн захиргааны төв байгууллагын төрийн сангийн нэгж, төсвийн нягтлан бодогч /цаашид "төрийн сан" гэх/-оос бүрдэнэ.

36.2.Төв төрийн сан нь санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, аймаг, нийслэл, сум, дүүргийн төрийн сан нь тухайн шатны Засаг даргын Тамгын газрын дэргэд байна.

36.3.Сум, дүүрэгт үйл ажиллагаа явуулж байгаа төсвийн байгууллагын үйл ажиллагааны чиглэл болон төсвийн хэмжээг нь харгалзан төрөлжүүлж, тэдгээрт хамаарах төсвийн байгууллагуудад нягтлан бодох бүртгэлийн үйлчилгээ үзүүлэх нэгдсэн алба байгуулж болно." гэсэн заалтуудаар зохицуулагдаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Баруунбаян-Улаан сумын Төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн

байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Баруунбаян-Улаан сумын Төрийн сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2021 оны нийт зардлын 3 тэрбум 792.8 сая төгрөгөөс 1 хувиар буюу 37.9 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 28.4 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

#### 3.5.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 160.5 сая төгрөгөөр өссөн байна.




#### 3.5.2 Авлага

| Авлага / Үзүүлэлт | 2020 он | 2021 он | Зөрүү | Эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Ажиллагчидтай холбогдсон авлага | 4.42 | 3.99 | -0.43 | 2.8 |
| Төлбөртэй үйлчилгээний авлага | 0.00 | 46.97 | 46.97 | 33.4 |
| Татаас, санхүүжилтийн авлага | 2.5 | 0.0 | -2.50 | 0.0 |
| Зээлийн хүүгийн авлага | 8.42 | 5.42 | -3.00 | 3.9 |
| Бусад авлага | 182.8 | 84.1 | -98.71 | 59.8 |
| **ДҮН** | **198.13** | **140.46** | **-57.67** | **100** |




Тайлант оны нийт авлагын 59.8 хувийг бусад авах авлага эзэлж байна. Энэ нь эрсдэлээс хамгаалах сан, сум хөгжүүлэх сангийн хувь хүмүүсээс авах авлага байна.

### 3.5.3 Бараа материал

Бараа материалын үлдэгдэл өмнөх оноос 93.1 сая төгрөгөөр өссөн байна.

| Бараа материал / Үзүүлэлт | 2020 он | 2021 он | Зөрүү | Эзлэх хувь |
|---|---|---|---|---|
| Түүхий эд материал | 16.3 | 64.7 | 48.3 | 25 |
| Хангамжийн материал | 143.0 | 181.7 | 38.7 | 70 |
| Бэлэн бүтээгдэхүүн | 0.00 | 6.1 | 6.1 | 2 |
| Мал амьтад | 8.68 | 8.7 | 0.0 | 3 |
| **ДҮН** | **168.0** | **261.1** | **93.1** | **100** |




Тайлант онд бараа материалын үлдэгдэл тусгай зориулалтын материал, эм боох материал, бэлэн бүтээгдэхүүн, аж ахуйн материал, хүнсээр нэмэгдсэн байна.

### 3.5.4 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн үлдэгдэл өмнөх оноос 246.9 сая төгрөгөөр өссөн байна.

| Үзүүлэлт | Хөрөнгийн дүн |
|---|---|
| **Үндсэн хөрөнгийн оны эхний үлдэгдэл** | **4849.3** |
| **Нэмэгдсэн** | **266.9** |
| Худалдан авсан | 44.7 |
| Хандиваар | 76.9 |
| Бусад | 145.2 |
| Дахин үнэлгээний нэмэгдэл | 0.0 |
| **Хасагдсан** | **19.9** |
| Акталсан | 18.0 |
| Шилжүүлсэн | 1.9 |
| **ҮНДСЭН ХӨРӨНГИЙН ЭЦСИЙН ҮЛДЭГДЭЛ** | **5096.2** |

Баруунбаян-Улаан сумын Төрийн сангийн үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн нэгтгэлээр 266.9 сая төгрөгийн хөрөнгө шинээр бүртгэлд тусгаснаас 44.7 сая төгрөгийн

хөрөнгийг төсвийн хөрөнгөөр, 222.2 сая төгрөгийн хөрөнгийг үнэ төлбөргүйгээр хүлээн авч бүртгэлд тусгажээ. Харин 18.0 сая төгрөгийн хөрөнгийг акталсан, 1.9 сая төгрөгийн хөрөнгийг шилжүүлсэн байна.

**3.5.5 Өр төлбөр**

| Өглөг | 2020 он | 2021 он |
|---|---|---|
| Ажилчидтай холбогдсон өглөг | 0.2 | 23.1 |
| Бараа үйлчилгээний зардлын өглөг | 4.6 | 26.9 |
| Байгууллагад төлөх өглөг | 1.1 | 0.0 |
| Хувь хүмүүст төлөх өглөг | 0.3 | 0.0 |
| **Дүн** | **6.2** | **50.0** |

Тайлант онд өр төлбөр 43.8 сая төгрөгөөр өссөн ЭМТөв 47.0 сая, ЗДТГ 0.9 сая , ИТХ 0.6 сая, ЕБС 1.5 сая төгрөгийн өртэй гарсан байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

### 3.6.1 Орон нутгийн төсвийн орлого бүрдүүлэлт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Сумын ИТХ-ын 2020 оны 4/01 тоот тогтоолоор орон нутгийн төсөвт төвлөрүүлэх татварын болон татварын бус орлогыг 157.9 сая төгрөгөөр баталжээ. Гүйцэтгэлээр 182.2 сая төгрөгийн орлого төвлөрсөн байна.

| Орлогын төрөл | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|---|---|---|---|---|
| Үйл ажиллагааны орлого | 11.4 | 12.1 | 0.7 | 106.5 |
| Хөрөнгийн албан татвар буу | 1.3 | 1.5 | 0.2 | 116.4 |
| Улсын тэмдэгтийн хураамж | 1.2 | 0.7 | -0.5 | 62.2 |
| Хог хаягдлын хураамж | 7 | 7.8 | 0.8 | 111.9 |
| хадгаламжийн хүүгийн орлого | 39.9 | 42.9 | 3.0 | 107.5 |
| хүү торгуул | 6 | 7.9 | 1.9 | 131.3 |
| ан агнуурын орлого | 90 | 77.5 | -12.5 | 86.1 |
| Газрын төлбөр | 1.1 | 1.1 | 0.0 | 96.0 |
| малын албан татвар | | 30.6 | 30.6 | |
| **Нийт дүн** | **157.9** | **182.2** | **24.3** | **115.4** |

### 3.6.2 Орон нутгийн төлөвлөлт, гүйцэтгэл

2021 онд төсвийн төвлөрүүлэн захирагчийн үйл ажиллагааг санхүүжүүлэхээр 2 тэрбум 720.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас улсын төсвөөс 815.4 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 1 тэрбум 508.4 сая төгрөгийг , 129.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 28.3 сая төгрөгийг Нийгмийн даатгалын сангаас, 238.7 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр 808,7 сая төгрөгийг улсын төсвөөс, тусгай зориулалтын шилжүүлгээс 1 тэрбум 508.4 сая төгрөгийг , 129.5 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс, 29.2 сая төгрөгийг Нийгмийн даатгалын сангаас, 140.1 сая төгрөгийг төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас санхүүжилтийн эх үүсвэр бүрдүүлжээ.

Үүнээс бараа үйлчилгээний зардалд 2 тэрбум 329.9 сая төгрөг, хөрөнгийн зардалд 88.3 сая төгрөг, эргэн төлөгдөх зээлд 2.6 сая төгрөг, урсгал шилжүүлэгт 31.1 сая төгрөгийг зарцуулжээ.

**Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт төсвийн дансаар сумын хэмжээнд 197.8 сая төгрөгийн санхүүжилт авч бараа үйлчилгээний зардалд 170.7 сая төгрөг, тэтгэмж урамшуулалд 27.1 сая төгрөг зарцуулжээ.

### 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Асуудлын онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэгт онцлон дурдах зүйл байхгүй байна.

### 3.8 Аудитын гол асуудал

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 2 чиглэлээр аудитын 2 горим сорил гүйцэтгэсэн.

Материаллаг буруу тайлагналын өндөр үнэлэгдсэн эрсдэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал, тайлант хугацаанд гарсан нөлөө бүхий ажил гүйлгээ, үйл явдлыг аудитын гол асуудлыг тодорхойлоход харгалзаж үзсэн.

### 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Баруунбаян-Улаан сумын Төрийн сан нь 2021 онд 154 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст байршуулахаас 101 мэдээллийг ил тод мэдээлсэн, 53 мэдээллийн мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

### 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх онд зөрчил илрээгүй.

### 3.11 Аудитын үр өгөөжийн тооцоолол

Төлөвлөлтийн шатанд 10.0 сая төгрөгийн үр өгөөжийг төлөвлөсөн. Аудитаар тооцож бүртгэсэн үр өгөөж байхгүй.

## 4. Аудитын илрүүлэлт

Баруунбаян-Улаан сумын Төрийн сангийн 2021 оны нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансанд 53 мэдээлэл хугацаа хоцорсон зөрчилд 1 албан шаардлага өгсөн.

### 4.1 Харьяа байгууллагуудад илэрсэн зөрчлийн талаар

Аудитад хамрагдсан 10 байгууллагын 4 байгууллагад дүгнэлт гаргаж, /Соёлын төв, ЗДТГ, ЭМТөв, ЕБС, / 4 байгууллагыг түүвэрт хамруулсан./ Сум хөгжүүлэх сан, Цэцэрлэг, ИТХ, ОНХС/ Эрсдэлээс хамгаалах сан, Сумын Ерөнхий орлогын дансыг аудитад хамруулаагүй.

Харьяа байгууллагуудын зөрчлийн нэгтгэлээр 117.7 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч 34.1 сая төгрөгийн алдааг залруулж, залруулагдаагүй 0.1 сая төгрөгийн зөрчилд акт, 79.8 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага, 3.7 сая төгрөгийн зөрчилд 4 зөвлөмжийг хүргүүлсэн.

*-ЗГ-ын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчиж Соёлын төв 1.0 сая төгрөг, ИТХ 0.1 сая төгрөгөөр нормын хувцас бэлтгэсэн,*

- *Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой алдаа зөрчил илэрсэн. Үүнд:*

***ОНХС-** Тухайн ондоо багтааж хөрөнгө оруулалтын ажил нь дуусгаагүй үлдэгдэл санхүүжилтээ хөрөнгийн зардалд бичсэн байсан 17.5 сая төгрөгийг урьдчилж гарсан зардлаар бүртгүүлж залруулга хийгдсэн.*

***ИТХ-** Өр авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй. ХХОАТ дутуу суутгасан*

***Цэцэрлэг-** Мөнгөн гүйлгээний тайлангийн биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн худалдан авсан хөрөнгийн дүнгээс зөрүүтэй байсныг залруулсан.*

***Ерөнхий боловёролын сургууль-** Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дансны төлөвлөгөөний дагуу эргэлтийн хөрөнгийг бүртгэх Төсвийг хууль тогтоомжийн дагуу зарцуулж, тайлагнах, бараа материалын тодруулгын тайланд үнэ төлбөргүй авсан аж ахуйн материалын дүнг 615.0 мянган төгрөгөөр , санхүүгийн үр дүнгийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийн дүнг 469.7 мянган төгрөгөөр, мөнгөн гүйлгээний тайланд төвлөрүүлэх шилжүүлгийн дүнг 469.7 сая төгрөгийн залруулгыг тус тус хийв. Тайлант онд дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг 219.5 төгрөгөөр хэтрүүлж өөрийн нэмэлт орлогоос санхүүжүүлсэн , мөн сумын онцгой комиссын хуралдааны тэмдэглэлээр эргүүл жижүүр хийсэн хүмүүст 3991.0 мянган төгрөгийн хоол өгсөн*

***Эрүүл мэндийн төв-** Эм, эмнэлгийн хэрэгслийн орлого, зарлагыг бараа материалын тайлан, тооллогын бүртгэлд нэр төрлөөр тусгасан боловч санхүүгийн бүртгэлд бөөн дүнгээр бүртгэсэн. Ашиглах хугацаа дууссан үндсэн хөрөнгөнд үнэлгээ хийж, шинээр үнэ, хугацаа тогтоолгох шаардлагатай байна. Урсгал зардлын төсвөөс үндсэн хөрөнгө бэлтгэсэн. Шинжилгээний төлбөрийн орлогыг байгууллагын төрийн сан дахь нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлээгүй байна. Байгууллагын өөрийн орлогын 3.7 сая төгрөг, түүний зарцуулалтыг санхүүгийн тайлан, бүртгэлд тусгаагүй байна.*

- ***Нийцлийн аудитаар илэрсэн зөрчил***

***Ерөнхий боловсролын сургууль-*** *Шилэн дансанд Дотуур байрны хүүхдийн хоол, хүнс нийлүүлэх гэрээг "Арвин хос бүрд " ХХК 27141.0 мянган төгрөгийн, АУХ баян" ХХК 23430.0 мянган төгрөгийн сурагчдын үдийн хоол, хүнс нийлүүлэх гэрээ,"Арцат богд трейд" ХХК 17273.5 мянган төгрөгийн нийт 67844.5 мянган төгрөгийн мэдээллийг байршуулаагүй байна.*

Аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэлийг хүснэгтээр хавсаргав.

| дд | Байгууллагын нэр | Алдаа, зөрчлийн утга | Нийт алдаа | | | Зөвлөмж тоо | Нийт зөрчил | | | Нийт алдаа зөрчил | Материаллаг | | Материаллаг бус |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Нийт дүн | Залруул-сан | Залруулаг даагүй | | Нийт дүн | Акт | Албан шаардлага | | Залруул сан | Залруулаг -даагүй | |
| 1 | ББУ Соёлын төв /Бие даасан дүгнэлт | Бараа үйлчилгээний бусад зардлаас 1000.0 мянган төгрөгөөр нормын хувцас авсан | 0.0 | 0.0 | 0.0 | | 1000.0 | | 1000.0 | 1000.0 | | 1000.0 | |
| 2 | ББ-Улаан сумын ЗДТГ / бие даасан / | Зөрчилгүй | 0.0 | | | | 0.0 | | | 0.0 | | | |
| 3 | Баруунбаян-Улаан сумын эрүүл мэндийн төв /Бие даасан / | Байгууллагын өөрийн орлогын 3.7 сая төгрөг, түүний зарцуулалтыг санхүүгийн тайлан, бүртгэлд тусгаагүй байсан | 3725.0 | 3,725.0 | | | 0.0 | | | 3725.0 | 3,725.0 | 0.0 | |
| | | Шинжилгээний төлбөрийн орлогыг байгууллагын төрийн сан дахь нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлээгүй байна. | 3725.0 | | 3,725.0 | 1.0 | 0.0 | | | 3725.0 | 0.0 | 3,725.0 | |
| | | Урсгал зардлын төсвөөс үндсэн хөрөнгө бэлтгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д: "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасныг зөрчсөн. | 0.0 | | | | 2380.0 | | 2,380.0 | 2380.0 | 0.0 | 2,380.0 | |
| | | Ашиглах хугацаа дууссан үндсэн хөрөнгөнд үнэлгээ хийж, шинээр үнэ, хугацаа тогтоолгох шаардлагатай байна. | 0.0 | | | 1.0 | 0.0 | | | 0.0 | 0.0 | 0.0 | |
| | | Эм, эмнэлгийн хэрэгслийн орлого, зарлагыг бараа материалын тайлан, тооллогын бүртгэлд нэр төрлөөр тусгасан боловч санхүүгийн бүртгэлд бөөн дүнгээр бүртгэсэн тул тэдгээр хөрөнгийн зарцуулалтад бүртгэлээр | 0.0 | | | 1.0 | 0.0 | | | 0.0 | 0.0 | 0.0 | |

| | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | тавих хяналт хэрэгжихгүй байх эрсдэлтэй байна. | | | | | | | | | | | |
| 4 | Баруунбаян улаан сумын ЕБ сургууль/ Бие даасан/ | Тайлант онд дотуур байрны хүүхдийн хоолны зардлыг 219.5 төгрөгөөр хэтрүүлж өөрийн нэмэлт орлогоос санхүүжүүлсэн , мөн сумын онцгой комиссын хуралдааны тэмдэглэлээр эргүүл жижүүр хийсэн хүмүүст 3991.0 мянган төгрөгийн хоол өгсөн | 0.0 | | | | 4210.5 | | 4,210.50 | 4210.5 | - | 4,210.50 | - |
| | | Шилэн дансанд Дотуур байрны хүүхдийн хоол, хүнс нийлүүлэх гэрээг "Арвин хос бүрд " ХХК 27141.0 мянган төгрөгийн, АУХ баян" ХХК 23430.0 мянган төгрөгийн сурагчдын үдийн хоол, хүнс нийлүүлэх гэрээ,"Арцат богд трейд" ХХК 17273.5 мянган төгрөгийн нийт 67844.5 мянган төгрөгийн мэдээлэлийг байршуулаагүй байна. | 0.0 | | | | 67844.5 | | 67,844.50 | 67844.5 | - | - | 67,844.50 |
| | | Бараа материалын тодруулгын тайланд үнэ төлбөргүй авсан аж ахуйн материалын дүнг 615.0 мянган төгрөгөөр , санхүүгийн үр дүнгийн тайланд төвлөрүүлэх шилжүүлгийн дүнг 469.7 мянган төгрөгөөр, мөнгөн гүйлгээний тайланд төвлөрүүлэх шилжүүлгийн дүнг 469.7 сая төгрөгийн залруулгыг тус тус хийв. | 1554.4 | 1,554.40 | - | | 0.0 | | - | 1554.4 | 1,554.40 | | - |
| | | Байгууллагын нягтлан бодох бүртгэлийн дансны төлөвлөгөөний дагуу эргэлтийн хөрөнгийг бүртгэх Төсвийг хууль тогтоомжийн дагуу зарцуулж, тайлагнах | 0.0 | | | 1 | 0.0 | | | 0.0 | | | |

| | | | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | ББУ СХС/түүвэр | Зөрчилгүй | 0.0 | | | | 0.0 | | | 0.0 | | | |
| 6 | ББ-Улаан сумын Цэцэрлэг | Мөнгөн гүйлгээний тайлангийн биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал үндсэн хөрөнгийн тодруулга тайлангийн худалдан авсан хөрөнгийн дүнгээс зөрүүтэй байсныг залруулсан | 11300.0 | 11300.0 | | | 0.0 | | | 11300.0 | 11300.0 | | |
| 7 | ББ-Улаан сумын ИТХурал/ Түүвэр/ | ХХОАТ дутуу суутгасан | 0.0 | | 0.0 | | 106.5 | 106.5 | 0.0 | 106.5 | | 106.5 | |
| | | Хөдөлмөр хамгаалалын хувцас хийж ЗГ-ын 43-р тогтоол зөрчсөн | 0.0 | | 0.0 | | 350.0 | | 350.0 | 350.0 | | 350.0 | |
| | | Өр авлагын үлдэглийг тооцоо нийлж баталгаажуулаагүй | 0.0 | | 0.0 | | 4000.0 | 0.0 | 4000 | 4000.0 | | 4000.0 | |
| 8 | Баруунбаян-Улаан сумын ОНХС /түүвэр/ | Тухайн ондоо багтааж хөрөнгө оруулалтын ажил нь дуусгаагүй үлдэгдэл санхүүжилтээ хөрөнгийн зардалдбичсэн байсан 17.5 сая төгрөгийг урьдчилж гарсан зардлаар бүртгүүлж залруулга хийгдсэн. | 17500.0 | 17500 | | | 0.0 | | | 17500.0 | 17500 | 0 | 0 |
| | | **Дүн** | **37804.4** | **34079.4** | **3725.0** | **4.0** | **79891.5** | **106.5** | **79785.0** | **117695.9** | **34079.4** | **15772.0** | **67844.5** |

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

**5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл**

(сая төгрөгөөр)

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | Залруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| | Баруунбаян-Улаан сумын Төрийн сан | 1 | 0 | 0 | 00 | 0 | 0 | 1 | 0 | 0 | 0 |

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР О.БАТЖАРГАЛ

АУДИТЫН МЕНЕЖЕР Д.ГАНСҮХ

БЭЛТГЭСЭН: АУДИТОР Ц.МӨНХЗАЯА

2022 ОНЫ 03 ДУГААР САРЫН 16-НЫ ӨДӨР